


# Тэнгэр элч нар ба гай гамшгууд

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Илчлэл 16 дээрх Иоханы харсан гай гамшгууд биднийг санаа зовоход хүргэж болох талаар бодож үз. Гэсэн хэдий ч Есүс Христэд итгэх итгэлээ нэмэгдүүлэх нь бидэнд санаа зовоож буй асуудлуудаа даван туулахад тусална. Тэнгэр элч нар гамшгуудаа цуглахдаа Их Эзэний зан чанарыг гэрчилсэн гэдгийг тэмдэглэх нь чухал юм. Түүний зан чанарыг мэдэж авах нь бидэнд Түүнд итгэх итгэлээ нэмэгдүүлэхэд тусална.

Илчлэл 16:5 ба 7-г уншаад, тэнгэр элч нар Их Эзэнийг болон Түүний шүүлтийг хэрхэн дүрсэлсэн болохыг олж мэд. Тэнгэр элч нар юу гэж хэлсэн гэж бодож буй талаараа дараах бөмбөлгөн зайд бич.



- Түүний шүүлтийн талаар судлахдаа Их Эзэний зан чанарыг ойлгож авах нь бидэнд яагаад тустай байх вэ?
- Энэ нь Бурхан ямар байдгийг ойлгоход тань таны амьдралд хэрхэн тусалсан бэ? Есүс Христийн зан чанарыг дурсан санаж явах нь Түүнд итгэж найдахад тань хэрхэн тусалсан бэ?